ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

# САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН АУДИТ

## Хэнтий аймгийн Баянмөнх сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын хураангуй тайлан

**Аудитын код: ХЭА-2026/099/НА-СТА-ТШЗ**

Чингис хот

2026 он


Дарга, тэргүүлэх аудитор: Ж.Ганбаатар
Утас: 70562112 Цахим хаяг:khentii@audit.gov.mn

Аудитын менежер: Д.Оюунтуяа
Утас: 99775390 Цахим хаяг: oyuntuyad@audit.gov.mn

Аудитор: Х.Баярбаатар
Утас: 99058696 Цахим хаяг: bayarbaatarkha@audit.gov.mn

Цахим хаяг: www.audit.mn


Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дээрх хаягаар авна уу.

**АГУУЛГА**

**1.ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ** ..... 2

**Асуудлыг онцолсон хэсэг** ..... 2

**2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ** ..... 4

**3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ** ..... 9

**4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ** ..... 12

**5. Аудитын тайлангийн хавсралт** ..... 13

**Товчилсон үгийн жагсаалт**

| | |
|---|---|
| АДБОУС | Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт |
| ЗГНХ | Засгийн газрын нөөц хөрөнгө |
| ЗДНХөрөнгө | Засаг даргын нөөц хөрөнгө |
| СТА | Санхүүгийн тайлангийн аудит |
| ТШЗ | Төсвийн шууд захирагч |
| УСНББОУС | Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын |

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

АЗДТГ-ын 3 дугаар давхарт, Сариг баг, Хэрлэн сум,
Хэнтий аймаг, 23119, Утас/Факс: (976) 70562112,
Цахим шуудан: khentii@audit.gov.mn

2026.02.25 № 429

танай ______ -ны № ______ -т

ХЭНТИЙ АЙМГИЙН БАЯНМӨНХ СУМЫН ЗАСАГ ДАРГЫН ТАМГЫН ГАЗРЫН ДАРГЫН ҮҮРГИЙГ ТҮР ОРЛОН ГҮЙЦЭТГЭГЧ Ц.БОЛДБААТАР ТАНАА

## Хязгаарлалттай дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Хэнтий аймгийн Баянмөнх сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Бидний үзэж байгаагаар Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл хэсэгт тайлбарласан зүйлсийн үр нөлөөг эс тооцвол 2025 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, тайлант жилийн эцсээрх тэдгээрийн санхүүгийн үр дүн, мөнгөн гүйлгээ, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу бүхий л материаллаг байдлын үүднээс үнэн зөв толилуулсан байна.

### Хязгаарлалттай санал дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Санхүүгийн тайлангийн аудитаар илэрсэн зөрчлүүд нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс өндөр байна. Үүнд:

Ажиллагсдад урамшуулал давхардуулан олгосон, нөөцийн барааны өвс, тэжээлийг анхан шатны баримтгүй зарлагадсан, борлуулалтын орлогыг төсөвт төвлөрүүлдэггүй, санхүүгийн тайланд өглөгөөр тусгалгүй орхигдуулсан төлбөрийг шүүхийн шийдвэрээр барагдуулсан, нийгмийн даатгалын актны төлбөрийг төлсөн, ус ашиглалтын гэрээгүй, усны хэрэглээний тайлан, анхан шатны баримтын шаардлага хангахгүй баримтаар их хэмжээний зардал гаргасан, нэг удаагийн тэтгэмжийг илүү тооцож олгосон, төрийн захиргааны албан хаагчийн сул орон тоо гарсан тухай бүрд олон нийтэд нээлттэй мэдээлэх, төрийн албаны нөөцөөс нөхөх арга хэмжээ авдаггүй зэрэг зөрчлүүд нь Нягтлан бодох бүртгэлийн тухай, Нийгмийн даатгалын ерөнхий хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль болон санхүүгийн тайлагналын нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдэлтэй нийцэхгүй байна.

### Асуудлыг онцолсон хэсэг

Тайлант онд орон нутгийн төсвөөс 1,580,489.8 мянган төгрөгийн санхүүжилт авч, гүйцэтгэлээр 78.4 хувь буюу 1,239,082.1 мянган төгрөгийг зарцуулж, 341,407.7 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн байна.

Нэмэлт санхүүжилтийн дансанд 14,150.9 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, 83.7 хувь буюу 11,857.5 мянган төгрөгийг зарцуулж, 2,293.4 мянган төгрөгийг орон нутгийн төсөвт төвлөрүүлсэн.

**Аудитын гол асуудал**

Аудитаар мөнгөн хөрөнгө, авлага, үндсэн хөрөнгө, урьдчилж төлсөн зардал, цалингийн зардлыг аудитын чиглэл болгон чухалчлан авч үзэв.

Аудитаар нийт 84,380.8 мянган төгрөгийн алдаа, зөрчил илэрснээс нягтлан бодох бүртгэлтэй холбоотой 26,041.7 мянган төгрөгийн 2 алдааг аудитын явцад санхүүгийн тайланд залруулж, 45,245.9 мянган төгрөгийн зөрчилд 5 албан шаардлага өгч, 13,093.2 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоолоо.

Гол асуудлыг санхүүгийн тайлангийн аудитын хүрээнд бүхэлд нь харгалзаж, аудитын санал дүгнэлтээ илэрхийлэхэд авч үзсэн бөгөөд энэхүү гол асуудлын талаар бид тусад нь дүгнэлт гаргахгүй.

**Бусад асуудлын хэсэг**

Байгууллагын тайлант онд хэрэгжүүлэх гүйцэтгэлийн төлөвлөгөөний чанарын болон тоо хэмжээний хэрэгжилт 5 зорилтын хүрээнд 252 арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөснөөс, хэрэгжилт 88.8 хувьтай дүгнэгдсэн байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

**Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага**

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

**Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага**

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээш түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

## 2.АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

### 2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан /төгрөгөөр/

| Балансын үзүүлэлт | Эхний үлдэгдэл | Эцсийн үлдэгдэл |
|---|---|---|
| **ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН** | **270,626,697.44** | **249,536,275.93** |
| **МӨНГӨН ХӨРӨНГӨ** | **195,700.00** | **188,700.00** |
| **Банкинд байгаа бэлэн мөнгө** | **195,700.00** | **188,700.00** |
| **Төгрөг** | **195,700.00** | **188,700.00** |
| Арилжааны банк дахь харилцах | 7,000.00 | - |
| Бусад төсөл, нөөцийн харилцах | 188,700.00 | 188,700.00 |
| **АВЛАГА** | **-** | **1,993,329.00** |
| **Бусад авлага** | - | 1,993,329.00 |
| Байгууллагаас авах авлага | | 1,993,329.00 |
| **УРЬДЧИЛГАА** | **300,000.00** | **300,000.00** |
| Урьдчилж гарсан зардал | 300,000.00 | 300,000.00 |
| **БАРАА МАТЕРИАЛ** | **246,610,997.44** | **223,554,246.93** |
| **Хангамжийн материал** | **246,610,997.44** | **223,554,246.93** |
| Бичиг хэргийн материал | 2,646,500.00 | 2,646,500.00 |
| Аж ахуйн материал | 50,123,605.00 | 19,684,000.00 |
| Сэлбэг хэрэгсэл | 1,760,000.00 | - |
| Бусад хангамжийн материал | 192,080,892.44 | 201,223,746.93 |
| **НӨӨЦИЙН БАРАА** | **23,520,000.00** | **23,500,000.00** |
| Тэжээлийн нөөц | 23,520,000.00 | 23,500,000.00 |
| **ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН** | **3,128,423,270.21** | **3,013,646,159.23** |
| **ҮНДСЭН ХӨРӨНГӨ** | **3,128,423,270.21** | **3,013,646,159.23** |
| **Биет хөрөнгө** | **3,091,287,270.21** | **2,976,510,159.23** |
| Барилга, байгууламж, орон сууц | 2,978,253,980.00 | 3,036,593,142.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (598,385,779.30) | (837,541,137.37) |
| Авто-тээврийн хэрэгсэл | 462,231,800.00 | 499,731,800.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (173,037,555.69) | (215,755,889.07) |
| Машин тоног төхөөрөмж (компьютер) | 292,238,680.69 | 292,238,680.69 |
| Хуримтлагдсан элэгдэл | (219,220,933.78) | (239,957,024.58) |
| Тавилга, аж ахуйн эд хогшил | 48,767,659.39 | 6,226,100.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (47,581,699.03) | (5,494,432.95) |
| Зам, гүүрийн байгууламж | 697,280,679.30 | 866,280,679.30 |
| Хуримтлагдсан элэгдэл | (355,650,510.73) | (431,579,134.15) |
| Бусад үндсэн хөрөнгө | 19,429,100.00 | 9,404,700.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (13,038,150.64) | (3,637,324.64) |
| **Биет бус хөрөнгө** | **37,136,000.00** | **37,136,000.00** |
| Програм хангамж | 1,421,167.00 | 1,421,167.00 |
| Хуримтлагдсан элэгдэл | (1,421,167.00) | (1,421,167.00) |
| Бусад биет бус хөрөнгө | 37,136,000.00 | 37,136,000.00 |
| **НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II** | **3,399,049,967.65** | **3,263,182,435.16** |
| **НИЙТ ӨР ТӨЛБӨР** | **-** | **439,000.00** |
| **БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР** | - | **439,000.00** |
| **Өглөг** | - | **439,000.00** |
| **Бусад өглөг** | - | **439,000.00** |
| Байгууллагад төлөх өглөг | - | 439,000.00 |
| **ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН** | **3,399,049,967.65** | **3,262,743,435.16** |
| **Засгийн газрын хувь оролцоо** | **3,399,049,967.65** | **3,262,743,435.16** |
| Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан | 462,338,997.88 | 462,338,997.88 |
| Өмч: - төрийн | 462,338,997.88 | 462,338,997.88 |
| **Хуримтлагдсан үр дүн** | **2,862,980,554.67** | **2,726,674,022.18** |
| Өмнөх үеийн үр дүн | 2,862,980,554.67 | 2,862,973,554.67 |
| Тайлант үеийн үр дүн | - | (136,299,532.49) |
| Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү | 73,730,415.10 | 73,730,415.10 |
| **ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V** | **3,399,049,967.65** | **3,263,182,435.16** |

## 2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)** | **1,647,999,202.00** | **1,858,221,545.93** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **437,963,215.00** | **263,580,843.93** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **437,963,215.00** | **263,580,843.93** |
| 120004 | Төсөв байгууллагын өөрийн орлого | 437,963,215.00 | - |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 432,000.00 | - |
| 1200045 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого | 437,531,215.00 | |
| 1200017 | Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого - Үндсэн хөрөнгө | | 263,580,843.93 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,210,035,987.00** | **1,594,640,702.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **30,611,087.00** | **14,150,902.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 19,595,387.00 | 5,491,015.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 11,015,700.00 | 8,659,887.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **1,179,424,900.00** | **1,580,489,800.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,179,424,900.00 | 1,580,489,800.00 |
| **2** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН** | **1,485,149,470.92** | **1,994,521,078.42** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,485,149,470.92** | **1,994,521,078.42** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,240,973,755.12** | **1,631,394,782.38** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **483,479,456.47** | **685,600,563.61** |
| 210101 | Үндсэн цалин | 307,406,320.52 | 375,968,305.24 |
| 210102 | Нэмэгдэл | 146,784,335.95 | 268,326,926.37 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 11,525,000.00 | 40,850,000.00 |
| 210104 | Урамшуулал | 17,763,800.00 | 455,332.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **60,921,592.52** | **86,401,240.10** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,567,789.49 | 59,037,998.82 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,750,857.79 | 6,694,692.40 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,517,459.99 | 3,661,485.15 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,357,628.91 | 3,354,129.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,727,856.34 | 13,652,933.79 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **45,716,666.51** | **59,339,104.95** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,301,003.51 | 25,523,793.95 |
| 210302 | Түлш, халаалт | 20,964,163.00 | 18,263,311.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 9,451,500.00 | 15,552,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **80,286,990.00** | **83,353,290.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 9,012,700.00 | 7,349,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 64,749,000.00 | 30,717,185.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,276,790.00 | 3,054,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 3,248,500.00 | 42,232,605.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **35,766,670.00** | **23,185,450.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | - | 1,900,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 35,766,670.00 | 21,285,450.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **24,454,000.00** | **22,300,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 24,454,000.00 | 22,300,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **90,386,595.70** | **152,073,155.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 87,947,100.00 | 149,843,931.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,014,300.00 | 1,014,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 481,375.70 | 454,204.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 257,500.00 | 188,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 450,000.00 | 450,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 236,320.00 | 122,720.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **419,961,783.92** | **519,141,978.72** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 114,130,224.00 | 91,370,975.74 |
| 210903 | Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол | 305,831,559.92 | 427,771,002.98 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **244,175,715.80** | **363,126,296.04** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **25,649,500.00** | **21,418,463.46** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 13,642,200.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 17,268,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,381,500.00 | 7,776,263.46 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **218,526,215.80** | **341,407,732.58** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 218,526,215.80 | 341,407,732.58 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **300,100.00** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 300,100.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)** | **162,849,731.08** | **(136,299,532.49)** |
| **5** | **НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)** | **162,849,731.08** | **(136,299,532.49)** |

## 2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан /төгрөгөөр/

| Дансны код | Үзүүлэлт | Өмнөх оны гүйцэтгэл | Тайлант оны гүйцэтгэл |
|---|---|---|---|
| | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ** | **1,211,557,987.00** | **1,596,110,702.00** |
| **1** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)** | **1,211,557,987.00** | **1,596,110,702.00** |
| **12** | **ТАТВАРЫН БУС ОРЛОГО** | **1,522,000.00** | **573,254,000.00** |
| **120** | **Нийтлэг татварын бус орлого** | **1,522,000.00** | **573,254,000.00** |
| 120004 | **Төсөв байгууллагын өөрийн орлого** | **1,522,000.00** | **573,254,000.00** |
| 1200042 | Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих | 1,522,000.00 | 1,470,000.00 |
| 1200043 | Урьд оны үлдэгдэлээс санхүүжих | | 571,784,000.00 |
| **13** | **ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО** | **1,210,035,987.00** | **1,022,856,702.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **30,611,087.00** | **14,150,902.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 19,595,387.00 | 5,491,015.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 11,015,700.00 | 8,659,887.00 |
| **1320** | **Орон нутгийн төсвөөс санхүүжих** | **1,179,424,900.00** | **1,008,705,800.00** |
| 132001 | Урсгал үйл ажиллагааны санхүүжилт /орон нутгийн төсөвт байгууллага/ | 1,179,424,900.00 | 1,008,705,800.00 |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)** | **1,211,559,587.00** | **1,518,617,702.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,211,559,587.00** | **1,518,617,702.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **967,383,871.20** | **1,153,248,176.96** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **483,479,456.37** | **684,730,808.91** |
| 210101 | Үндсэн цалин | 310,671,780.47 | 305,939,519.05 |
| 210102 | Нэмэгдэл | 143,842,308.85 | 329,940,824.96 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 11,371,454.55 | 40,347,967.85 |
| 210104 | Урамшуулал | 17,593,912.50 | 514,500.00 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | - | 7,987,997.05 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **60,921,592.62** | **86,401,240.10** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 41,584,949.49 | 59,037,998.82 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 4,746,567.79 | 6,694,692.40 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 2,515,314.99 | 3,661,485.15 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 2,355,483.91 | 3,354,129.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 9,719,276.44 | 13,652,933.79 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **42,860,166.51** | **59,207,104.95** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 15,301,003.51 | 25,523,793.95 |
| 210302 | Түлш, халаалт | 20,964,163.00 | 18,263,311.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 6,595,000.00 | 15,420,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **41,673,640.00** | **35,237,565.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 4,509,700.00 | 5,988,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 31,775,150.00 | 23,809,065.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 3,587,790.00 | 3,054,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 1,801,000.00 | 2,386,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **2,800,000.00** | **2,637,000.00** |
| 210502 | Хоол, хүнс | 1,000,000.00 | |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 1,800,000.00 | 2,637,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **41,748,370.00** | **33,038,150.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 15,200,000.00 | 10,227,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 26,548,370.00 | 22,810,450.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **24,544,000.00** | **21,600,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 24,544,000.00 | 21,600,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **114,969,445.70** | **171,130,948.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж | 112,529,950.00 | 168,911,724.00 |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,014,300.00 | 1,014,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 481,375.70 | 444,204.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 257,500.00 | 188,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 450,000.00 | 450,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 236,320.00 | 122,720.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **154,387,200.00** | **59,265,360.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 154,387,200.00 | 59,265,360.00 |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **244,175,715.80** | **365,369,525.04** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **25,649,500.00** | **21,668,463.46** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | - | 13,642,200.00 |
| 213208 | Хөдөө орон нутагт тогтвор суурьшилтай ажилласан албан хаагчдад төрөөс үзүүлэх дэмжлэг | 17,268,000.00 | - |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 8,381,500.00 | 8,026,263.46 |
| **2134** | **Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, санхүүжилт** | **218,526,215.80** | **343,701,061.58** |
| 213403 | Төвлөрүүлэх шилжүүлэг | 218,526,215.80 | 341,407,732.58 |
| **2135** | **Төсвийн захирагчдаас олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **-** | **2,293,329.00** |
| 213503 | Төвлөрүүлэх шилжүүлэг | | 2,293,329.00 |
| **3** | **ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)** | **(1,600.00)** | **77,493,000.00** |
| **5** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)** | - | **77,500,000.00** |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | - | **77,500,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | - | **77,500,000.00** |
| 223001 | Бусад хөрөнгө | - | 77,500,000.00 |
| **6** | **ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)** | **-** | **(77,500,000.00)** |
| **8** | **НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)** | (1,600.00) | (7,000.00) |
| **9** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл** | **197,300.00** | **195,700.00** |
| **10** | **Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл** | **195,700.00** | **188,700.00** |

## 2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан /төгрөгөөр/

| Код | Үзүүлэлт | Засгийн газрын оруулсан капитал | Дахин үнэлгээний нөөц | Хуримтлагдсан дүн | Бусад | Засгийн газрын хувь оролцооны нийт дүн |
|---|---|---|---|---|---|---|
| C01 | **2021 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | 462,338,997.88 | 73,730,415.10 | 2,700,130,823.59 | | 3,236,200,236.57 |
| C02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| C03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **462,338,997.88** | **73,730,415.10** | **2,700,130,823.59** | **-** | **3,236,200,236.57** |
| C04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт | - | - | - | | - |
| C05 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт | - | - | - | | - |
| C06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| C07 | Тайлант үеийн үр дүн | - | - | 162,849,731.08 | | 162,849,731.08 |
| C08 | **2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **462,338,997.88** | **73,730,415.10** | **2,862,980,554.67** | **-** | **3,399,049,967.65** |
| D01 | **2023 оны 1-р сарын 1-нээрх үлдэгдэл** | **462,338,997.88** | **73,730,415.10** | **2,862,980,554.67** | **-** | **3,399,049,967.65** |
| D02 | Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт | - | - | - | | - |
| D03 | **Дахин илэрхийлсэн үлдэгдэл** | **462,338,997.88** | **73,730,415.10** | **2,862,973,554.67** | **-** | **3,399,042,967.65** |
| D04 | Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D05 | Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт | - | - | - | | - |
| D06 | Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз | - | - | - | | - |
| D07 | Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү | - | - | - | | - |
| D08 | Тайлант үеийн үр дүн | - | - | (136,299,532.49) | | (136,299,532.49) |
| D09 | **2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл** | **462,338,997.88** | **73,730,415.10** | **2,726,674,022.18** | **-** | **3,262,743,435.16** |

## 2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан /төгрөгөөр/

| Эдийн засгийн ангилал | Үзүүлэлт | Тайлант оны | |
|---|---|---|---|
| | | Батлагдсан төлөвлөгөө | Гүйцэтгэл |
| **2** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **1,580,489,800.00** | **1,239,082,067.42** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **1,502,989,800.00** | **1,161,582,067.42** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **1,479,989,500.00** | **1,140,163,603.96** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **741,421,800.00** | **684,216,308.91** |
| 210101 | Үндсэн цалин | 321,663,600.00 | 305,939,519.05 |
| 210102 | Нэмэгдэл | 351,374,400.00 | 329,940,824.96 |
| 210103 | Унаа хоолны хөнгөлөлт | 33,000,000.00 | 40,347,967.85 |
| 210105 | Гэрээт ажлын хөлс | 35,383,800.00 | 7,987,997.05 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **97,679,100.00** | **85,642,072.10** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 62,608,600.00 | 58,278,830.82 |
| 210202 | Тэтгэмжийн даатгал | 7,317,600.00 | 6,694,692.40 |
| 210203 | ҮОМШӨ-ний даатгал | 4,756,200.00 | 3,661,485.15 |
| 210204 | Ажилгүйдлийн даатгал | 3,361,400.00 | 3,354,129.94 |
| 210205 | Эрүүл мэндийн даатгал | 19,635,300.00 | 13,652,933.79 |
| **2103** | **Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал** | **168,362,100.00** | **59,207,104.95** |
| 210301 | Гэрэл, цахилгаан | 76,049,000.00 | 25,523,793.95 |
| 210302 | Түлш, халаалт | 74,713,100.00 | 18,263,311.00 |
| 210303 | Цэвэр, бохир ус | 17,600,000.00 | 15,420,000.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **51,473,100.00** | **32,889,260.00** |
| 210401 | Бичиг хэрэг | 9,000,000.00 | 5,988,000.00 |
| 210402 | Тээвэр, шатахуун | 30,000,000.00 | 21,460,760.00 |
| 210403 | Шуудан, холбоо, интернэтийн төлбөр | 4,685,000.00 | 3,054,500.00 |
| 210406 | Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс | 7,788,100.00 | 2,386,000.00 |
| **2105** | **Нормативт зардал** | **2,637,000.00** | **2,637,000.00** |
| 210503 | Нормын хувцас, зөөлөн эдлэл | 2,637,000.00 | 2,637,000.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **40,678,600.00** | **30,038,150.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 8,528,400.00 | 8,327,700.00 |
| 210604 | Урсгал засвар | 32,150,200.00 | 21,710,450.00 |
| **2107** | **Томилолт, зочны зардал** | **32,127,200.00** | **21,600,000.00** |
| 210702 | Дотоод албан томилолт | 32,127,200.00 | 21,600,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **186,695,500.00** | **164,675,348.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр | 182,572,500.00 | 162,456,124.00 |
| 210802 | Аудит, баталгаажуулалт, зэрэглэл тогтоох | 622,800.00 | - |
| 210803 | Даатгалын үйлчилгээ | 1,014,300.00 | 1,014,300.00 |
| 210804 | Тээврийн хэрэгслийн татвар | 536,400.00 | 444,204.00 |
| 210805 | Тээврийн хэрэгслийн оношлогоо | 245,600.00 | 188,000.00 |
| 210806 | Мэдээлэл, технологийн үйлчилгээ | 740,400.00 | 450,000.00 |
| 210807 | Газрын төлбөр | 963,500.00 | 122,720.00 |
| **2109** | **Бараа үйлчилгээний бусад зардал** | **158,915,100.00** | **59,258,360.00** |
| 210901 | Бараа үйлчилгээний бусад зардал | 156,503,200.00 | 59,258,360.00 |
| 210902 | Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх | 2,411,900.00 | - |
| **213** | **УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ** | **23,000,300.00** | **21,418,463.46** |
| **2132** | **Бусад урсгал шилжүүлэг** | **23,000,300.00** | **21,418,463.46** |
| 213205 | Төрөөс иргэдэд олгох тэтгэмж, урамшуулал | 13,642,200.00 | 13,642,200.00 |
| 213209 | Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал | 9,358,100.00 | 7,776,263.46 |
| **22** | **ХӨРӨНГИЙН ЗАРДАЛ** | **77,500,000.00** | **77,500,000.00** |
| **2200** | **Дотоод эх үүсвэрээр** | **77,500,000.00** | **77,500,000.00** |
| 223001 | Бусад хөрөнгө | 77,500,000.00 | 77,500,000.00 |
| | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **1,580,489,800.00** | **1,239,082,067.42** |
| **1320** | **ОРОН НУТГИЙН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ** | **1,580,489,800.00** | **1,239,082,067.42** |
| 132001 | Орон нутгийн төсвөөс | 1,580,489,800.00 | 1,239,082,067.42 |
| **61** | **БАЙГУУЛЛАГЫН ТОО** | 1.00 | 1.00 |
| 610001 | Төсвийн байгууллага | 1.00 | 1.00 |
| **62** | **АЖИЛЛАГСАДЫН ТОО** | 21.00 | 18.00 |
| 620001 | Удирдах ажилтан | 7.00 | 7.00 |
| 620002 | Гүйцэтгэх ажилтан | 7.00 | 5.00 |
| 620003 | Үйлчлэх ажилтан | 5.00 | 4.00 |
| 620004 | Гэрээт ажилтан | 2.00 | 2.00 |

**2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан** **/төгрөгөөр/**

| Дансны код | Үзүүлэлт | Гүйцэтгэл |
|---|---|---|
| **I** | **НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН** | **14,150,902.00** |
| **21** | **УРСГАЛ ЗАРДАЛ** | **14,150,902.00** |
| **210** | **БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ** | **11,857,573.00** |
| **2101** | **Цалин хөлс болон нэмэгдэл урамшил** | **514,500.00** |
| 210104 | Урамшуулал | 514,500.00 |
| **2102** | **Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл** | **759,168.00** |
| 210201 | Тэтгэврийн даатгал | 759,168.00 |
| **2104** | **Хангамж, бараа материалын зардал** | **2,348,305.00** |
| 210402 | Тээвэр, шатахуун | 2,348,305.00 |
| **2106** | **Эд хогшил, урсгал засварын зардал** | **3,000,000.00** |
| 210601 | Багаж, техник, хэрэгсэл | 1,900,000.00 |
| 210604 | Урсгал засвар | 1,100,000.00 |
| **2108** | **Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж** | **5,235,600.00** |
| 210801 | Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний | 5,235,600.00 |
| **2133** | **Олгосон санхүүжилт, шилжүүлэг** | **2,293,329.00** |
| 213403 | Орон нутгийн төсвийн ерөнхийлөн захирагчдад олгох татаас, төвлөрүүлэх шилжүүлэг | 2,293,329.00 |
| **II** | **ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР** | **14,150,902.00** |
| **1311** | **Нэмэлт санхүүжилтийн орлого** | **14,150,902.00** |
| 131104 | Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө | 5,491,015.00 |
| 131105 | Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого | 8,659,887.00 |

## 3. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

**Аудитаар нийт 84,380.8 төгрөгийн 8 алдаа, зөрчил илэрснээ аудитын явцад 26,041.7 мянган төгрөгийн 2 алдааг санхүүгийн тайланд залруулсан.**

**Үүнд:**

*Залруулсан алдаа:*

1. Барилга байгууламж данс бүртгэлд тусгасан 1-р багийн төв БЗД нэршилтэй хөрөнгө нь 20,246.9 мянган төгрөгийн үлдэгдэл зөрүүтэй тайлагнасан байна.
2. Машин тоног төхөөрөмж данс бүртгэлд тусгасан 5,794.8 мянган төгрөгийн өртөгтэй 2 ширхэг мотоцикл ашиглах хугацаа оруулаагүйн улмаас элэгдлийн зардалгүй бүртгэгдсэн алдаа нь УСНББОУС 1 - Толилуулга, санхүүгийн тайлагналын "Үнэн зөв байдал", "Толилуулга ба тодруулга" батламж мэдэгдлүүдийг хангахгүй байна.

**Аудитаар нийт 58,339.1 төгрөгийн 6 зөрчил илэрлээ.**

**Аудитаар 13,093.2 мянган төгрөгийн зөрчилд 3 төлбөрийн акт тогтоов.**

### 3.1 Төлбөрийн акт

1. Тайлант онд ажлын үр дүнгээр урамшуулал авсан 2 ажилтанд балансын үр дүнгийн урамшуулал нэрээр 5,327.0 мянган төгрөгийг давхардуулан олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.
   Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох

журам"-ын 1.2-т "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно:", 1.2.2-т "төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид.", 2.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно.", 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

2. Тайлант онд сумын Засаг даргаар ажиллаж байсан иргэнд олгох нэг удаагийн тэтгэмжийг буруу тооцоолон 772.2 мянган төгрөгийг илүү олгосон байна.

   Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.", Засаг захиргаа , нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1-д "Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно.", Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д "төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;" гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

3. Бараа материалын тайлангийн нөөцийн бараа данснаас 6,994.0 мянган төгрөгийн өвс, тэжээлийг Сумын онцгой комиссын шийдвэр, анхан шатны баримтын бүрдэл хангахгүй зарлагдаж, орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна.

   Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", 16 дугаар зүйлийн 16.5.2. "төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих", 16.5.6 "дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 "Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ", 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5 "дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах", Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д "Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно." гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

**Аудитаар нийт 45,245.9 мянган төгрөгийн зөрчилд 3 албан шаардлага хүргүүлэв.**

**3.2 Албан шаардлага**

1. Төсвийн хөрөнгийг зориулалт бусаар зарцуулсан нийт 44,622.3 мянган төгрөгийн 3 зөрчил илэрсэн. Үүнд:

1.1 Нутгийн удирдлагын ордны барилгын зураг төслийг 2020 онд Анга транс ХХК-р хийлгэж, санхүүгийн тайланд өглөгөөр тусгаагүй, 2024 оны 9 сарын 11-ний өдрийн Шүүхийн шийдвэрээр 27,753.0 мянган төгрөгийг төлж төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

1.2 Ус ашиглалтын гэрээгүй, усны хэрэглээний тайлан, анхан шатны баримтын шаардлага хангахгүй баримтаар усны төлбөрийг байгууллагын үйлчлэгч П.Бадамсүрэнгийн данс руу 9,828.0 мянган төгрөгийг, Алаг адуут буян ХХК-руу 4,200.0 мянган төгрөг нийт 14,028.0 мянган төгрөгийн усны төлбөр шилжүүлж төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан.

1.3 ЗДТГ-ын албан хаагчдад 2022-2023 онд олгосон түлээ нүүрсний хөнгөлөлт, мал тооллогын судалгаа, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого болох хөдөлмөрийн хөлсөнд ногдох шимтгэл, алдангийг нөхөн төлүүлэх 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 23 тоот Нийгмийн даатгалын улсын байцаагчийн актын төлбөр 2,841.3 мянган төгрөгийг өглөг үүсгэлгүйгээр нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас төлсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; 20.2.6-д “эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2. Сумын Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн Б/35 тоот тушаалаар санхүүгийн албаны даргын сул орон тоог нөхөгдөх хүртэл хугацаанд Засаг даргын тамгын газрын нягтлан бодогчид, үндсэн цалингийн 40 хувийн 623.6 мянган төгрөгийн нэмэгдэл цалинг үндэслэлгүй олгосон.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4-43.5.”Албан үүргийг түр орлон гүйцэтгэх албан хаагч нь үндсэн албан тушаалаасаа чөлөөлөгдөхгүйгээр албан үүргийнхээ зэрэгцээ түр орлох албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг хариуцна.” 43.5.”Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална”. Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд, цалин урамшуулал олгох журмын 2.1-д Төрийн албаны тухай хуулийн 42.1-д заасан үндэслэлээр эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг 2-6 сар хүртэл хугацаагаар түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид цалингийн зөрүүг олгоно. 2.2-д Энэ журмын 2.1-д заасан түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно гэснийг тус тус зөрчсөн байна.

3. Тус байгууллага нь төрийн захиргааны албан хаагчийн сул орон тоо гарсан тухай бүрд олон нийтэд мэдээлэхгүй, Төрийн албаны салбар зөвлөлд сул орон тооны захиалга хүргүүлэлгүй Засаг даргын тамгын газрын дарга, Төрийн сангийн мэргэжилтэн, Санхүүгийн албаны дарга, Хоршоо, хүнс, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн, Нийгмийн бодлогын мэргэжилтэн нарын албан үүргийг шаардлага хангаагүй иргэдээр түр орлон гүйцэтгүүлж байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.” гэснийг зөрчсөн байна.

**3.3 Зөвлөмж**

Байхгүй.

***Нийт илрүүлсэн 58,339.1 мянган төгрөгийн зөрчил нь бидний тогтоосон материаллаг байдлын түвшнээс их тул Хязгаарлалттай дүгнэлт өглөө.***

## 4. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

### Санхүүгийн тайлангийн аудитын алдааны нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Алдааны товч утга | Нийт алдаа | | Мэдээллийг тусгахгүй орхигдуулсан | | Буруу тусган илэрхийлсэн | | Үүнээс: | | | | Зөвлөмж | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | | | | | Залруулсан | | Залруулагдаагүй | | | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үндсэн хөрөнгийг данс бүртгэлд хасах үлдэгдэлтэй тусгасан. | 1 | 20,246.9 | | | 1 | 20,246.9 | 1 | 20,246.9 | | | | |
| Мотоциклыг ашиглалтын хугацаагүй бүртгэлд тусгасан. | 1 | 5,794.8 | | | 1 | 5,794.8 | 1 | 5,794.8 | | | | |
| **Дүн** | **2** | **26,041.7** | | | **2** | **26,041.7** | **2** | **26,041.7** | | | | |

### Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | | Хариуцлага тооцуулах албан шаардлага | | Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| Үр дүнгийн урамшуулал давхардуулан олгосон. | 1 | 5,327.0 | 1 | 5,327.0 | | | | | | | | |
| Нэг удаагийн тэтгэмж илүү олгосон. | 1 | 772.2 | 1 | 772.2 | | | | | | | | |
| Өвс, тэжээлийн нөөцийн зарлагдсан боловч орлого төвлөрүүлээгүй | 1 | 6,994.0 | 1 | 6,994.0 | | | | | | | | |
| Шүүхийн шийдвэрийн дагуу барилын зургы үнэ төлсөн. Усны төлбөр үйлчлэгчийн дансруу шилжүүлсэн. Нийгмийн даатгалын актны төлбөр төлсөн. | 1 | 44,622.3 | | | 1 | 44,622.3 | | | | | | |

| | | | | | | | | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|---|
| ЗДТГ-ын нягтлан бодогчид түр орлон гүйцэтгэсний нэмэгдэл цалин олгосон. | 1 | 623.6 | | | 1 | 623.6 | | | | | | |
| Шаардлага хангаагүй иргэдээр түр орлон гүйцэтгүүлсэн. | 1 | - | | | 1 | - | | | | | | |
| **Дүн** | **6** | **58,339.1** | **3** | **13,093.2** | **3** | **45,245.9** | | | | | | |

## Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

/мянган төгрөгөөр/

| Зөрчлийн товч утга | Нийт зөрчил | | Үүнээс | | | | | |
|---|---|---|---|---|---|---|---|---|
| | | | Төлбөрийн акт | | Албан шаардлага | | Зөвлөмж | |
| | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн | Тоо | Дүн |
| **Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| **Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилттэй холбоотой зөрчил** | | | | | | | | |
| | | | | | | | | |
| **Дүн** | | | | | | | | |
| **Нийт дүн** | | | | | | | | |

## 5. Аудитын тайлангийн хавсралт

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 76- А2370456 Чингис хот

ХЭА-2026/099/НА-СТА-ТШ3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянмөнх сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тайлант онд ажлын үр дүнгээр урамшуулал авсан 2 ажилтанд балансын үр дүнгийн урамшуулал нэрээр 5,327,000.00 (таван сая гурван зуун хорин долоон мянган) төгрөгийг давхардуулан олгож, төсвийг арвилан хэмнэлтгүй зарцуулсан байна.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-т "Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах", Засгийн газрын 2019 оны 5 дугаар тогтоолын 3 дугаар хавсралт "Төрийн албан хаагчид мөнгөн урамшуулал олгох журам"-ын 1.2-т "Төрийн албан хаагчийн ажлын гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн төрийн албан хаагчид дараах эрх бүхий албан тушаалтан мөнгөн урамшуулал олгоно:", 1.2.2-т "төсвийн шууд захирагч нь байгууллагын төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн үнэлгээ, улирлын ажлын үр дүнг үндэслэн холбогдох гүйцэтгэлийн үнэлгээний журамд тодорхойлсон мөнгөн урамшуулал авах нөхцөлийг хангасан төрийн албан хаагчид.", 2.1-т "Хуульд өөрөөр заагаагүй бол улирлын ажлын үр дүнгийн мөнгөн урамшууллыг хөдөлмөрийн дотоод журам, албан тушаалын тодорхойлолт, төрийн албан хаагчийн гүйцэтгэлийн төлөвлөгөө, хөдөлмөрийн гэрээнд заасан ажил, үүргээ хангалттай гүйцэтгэсэн, ажлын байранд хөдөлмөрийн сахилга, ёс зүйн зөрчил гаргаагүй албан хаагчид олгоно.", 2.2-т "Төрийн албан хаагчид улирлын ажлын үр дүнгээр олгох мөнгөн урамшууллын дээд хэмжээ нь албан хаагчийн албан тушаалын сарын үндсэн цалингийн 50 хувиас хэтрэхгүй байна." гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т "*Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.*", Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох" журмын 4.2.3.3-т "цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон;" гэсэн заалтыг үндэслэн **ТОГТООХ** нь:

1. Давхардуулан олгосон 5,327,000.00 (таван сая гурван зуун хорин долоон мянган) төгрөгийг нягтлан бодогч Н.Батаа, нярав Ч.Баярмаа нараар төлүүлж, аймгийн Төрийн сан банк дахь "Нэр заагдаагүй бусад орлого" 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Болдбаатарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Х.БАЯРБААТАР

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АКТ**

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 77-А2370456 Чингис хот

ХЭА-2026/099/НА-СТА-ТШ3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баянмөнх сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ.Үүнд:

Тайлант онд сумын Засаг даргаар ажиллаж байсан иргэнд олгох нэг удаагийн тэтгэмжийг буруу тооцоолон 772,200.00 (долоон зуун далан хоёр мянга хоёр зуун) төгрөгийг илүү олгосон байна.

Энэ нь Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн 13.7-д *“Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”,* Засаг захиргаа , нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 78 дугаар зүйлийн 78.1-д *“Аймаг, сум, нийслэл, дүүргийн Хурлын дарга болон бүх шатны Засаг дарга ээлжит сонгуулийн дүнд албан тушаалаасаа чөлөөлөгдсөн бол тэдгээрт урьд нь эрхэлж байсан албан тушаалын зургаан сарын цалинтай тэнцэх хэмжээний нэг удаагийн тэтгэмж олгоно.”,* Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1-д *“төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах;”* гэсэн заалтыг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т *“Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох “ журмын 4.2.3.3-т “цалин хөлс, шагнал урамшуулал, тэтгэмжийг зөрүүтэй тооцож олгосон.” гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Илүү олгосон тэтгэмжийн 772,200.00 (долоон зуун далан хоёр мянга хоёр зуун) төгрөгийг буруу тооцон олгосон нягтлан бодогч Н.Батаагаар төлүүлж аймгийн Төрийн сан банк дахь “Нэр заагдаагүй бусад орлого” 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх

2. Актын биелэлтийг 2026 оны 05 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Болдбаатарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Х.БАЯРБААТАР

# ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
# ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
# АКТ

2026 оны 02 сарын 25 өдөр Дугаар 68 - А2370456 Чингис хот

ХЭА - 2026/099/НА-СТА-ТШ3

Төлбөр барагдуулах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баянмөнх сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Бараа материалын тайлангийн нөөцийн бараа данснаас 6,994,000.00 (зургаан сая есөн зуун ерэн дөрвөн мянган) төгрөгийн өвс, тэжээлийг Сумын онцгой комиссын шийдвэр, анхан шатны баримтын бүрдэл хангахгүй зарлагдаж, борлуулалтын орлогыг төсөвт төвлөрүүлээгүй байна.

*Энэ нь Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах”, 16 дугаар зүйлийн 16.5.2. “төсөв, хөтөлбөрийг хэрэгжүүлэх талаар төсвийн ерөнхийлөн захирагчтай байгуулсан гэрээний хүрээнд төсвийн хөрөнгийг удирдах, зарцуулалтад нь хяналт тавих”, 16.5.6 “дотоод аудитын үйл ажиллагааг хэрэгжүүлэх”, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 5 дугаар зүйлийн 5.1.4 "Үнэн зөв байх", 18 дугаар зүйлийн 18.1 “Нягтлан бодох бүртгэлийг удирдан зохион байгуулах үүргийг аж ахуйн нэгж, байгууллагын гүйцэтгэх удирдлага хүлээнэ”, 20 дугаар зүйлийн 20.2.4 "нягтлан бодох бүртгэл хөтлөлт нь энэ хууль болон санхүүгийн бусад хууль тогтоомжид заасан шаардлагад нийцэж байгаа эсэхийг хянах", 20.2.5 “дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах”,* Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 13 дугаар зүйлийн *13.7-д “Анхан шатны баримтын бүрдэлгүй ажил, гүйлгээг бүртгэх, санхүүгийн тайланд тусгахыг хориглоно.”* гэсэн заалтуудыг зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.2-т *“Шалгагдагч этгээд төсөв, санхүү, нягтлан бодох бүртгэлийн үйл ажиллагаа болон төсвийн орлого бүрдүүлэх, зарцуулах, нийтийн өмч, хөрөнгө олж бэлтгэх, ашиглах, зарцуулах, хадгалах, хамгаалахтай холбоотой хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн бол төлбөрийн акт тогтооно.”*, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 дугаар тушаалаар баталсан “Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох “ журмын 4.2.3.5-д “бүртгэл, тооцоог зөрүүтэй тооцоолсноос үр дагавар үүссэн.” гэсэн заалтыг үндэслэн ТОГТООХ нь:

1. Анхан шатны баримтгүй зарцуулсан 6,994,000.00 (зургаан сая есөн зуун ерэн дөрвөн мянган) төгрөгийг өвс, тэжээлийн зарцуулалтад дотоод хяналт хэрэгжүүлээгүй нягтлан бодогч Н.Батаагаар төлүүлж, аймгийн Төрийн сан банк дахь “Нэр заагдаагүй бусад орлого” 100180000955 тоот дансанд төвлөрүүлэх.

2. Актын биелэлтийг 2026 оны 09 дугаар сарын 20-ны дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг ЗДТГ-ын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Болдбаатарт хариуцуулав.

**ТӨЛБӨРИЙН АКТ ТОГТООСОН:**

ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Х.БАЯРБААТАР

**ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ**
**ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**
**АЛБАН ШААРДЛАГА**

2026 оны 02 сарын 25 Дугаар 227-А2370466 Чингис хот
ХЭА-2026/099/НА-СТА-ТШ3

Зөрчлийг таслан зогсоох тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Баянмөнх сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

1. Нутгийн удирдлагын ордны барилгын зураг төслийг 2020 онд "Анга транс" ХХК-аар хийлгэж, санхүүгийн тайланд өглөгөөр тусгалгүй орхигдуулсан, 2024 оны 9 сарын 11-ний өдрийн Шүүхийн шийдвэрээр 27,753,044.00 (хорин долоон сая долоон зуун тавин гурван мянга дөчин дөрвөн) төгрөгийг төлж төсвийг зориулалт бусаар зарцуулсан байна.

2. Ус ашиглалтын гэрээгүй, усны хэрэглээний тайлан, анхан шатны баримтын шаардлага хангахгүй баримтаар усны төлбөрийг байгууллагын үйлчлэгч П.Бадамсүрэнгийн данс руу 9,828,000.00 (есөн сая найман зуун хорин найман мянган) төгрөгийг, "Алаг адуут буян" ХХК-ийн данс руу 4,200,000.00 (дөрвөн сая хоёр зуун мянган) төгрөг нийт 14,028,000.00 (арван дөрвөн сая хорин найман мянган) төгрөгийн усны төлбөр шилжүүлж төсвийн хөрөнгийг зориулалт бус зарцуулсан.

3. ЗДТГ-ын албан хаагчдад 2022-2023 онд олгосон түлээ нүүрсний хөнгөлөлт, мал тооллогын судалгаа, хөлсөөр ажиллах гэрээ байгуулан цалин хөлс, түүнтэй адилтгах орлого болох хөдөлмөрийн хөлсөнд ногдох шимтгэл, алдангийг нөхөн төлүүлэх 2024 оны 12 дугаар сарын 24-ний өдрийн 23 тоот Нийгмийн даатгалын улсын байцаагчийн актын төлбөр 2,841,263.00 (хоёр сая найман зуун дөчин нэгэн мянга хоёр зуун жаран гурван) төгрөгийг өглөг үүсгэлгүйгээр нэг удаагийн тэтгэмж урамшууллын зардлаас төлсөн.

Энэ нь Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.5-д "батлагдсан төсвийг зориулалтын дагуу зарцуулах;" Төсвийн тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.2.5.дансны өглөг, авлага ба төлбөрийн тооцоог хянах, ажил, гүйлгээг гарахаас нь өмнө хянан, баталгаажуулах; 20.2.6-д "эд хөрөнгийн болон төлбөр тооцооны тооллого хийх, үр дүнг шийдвэрлэх, бэлтгэн нийлүүлэгч, худалдан авагчтай тооцоо хийж, үлдэгдлийг баталгаажуулж, баримтжуулах ажлыг зохион байгуулах, удирдах;" гэж заасныг тус тус зөрчсөн байна.

Иймд Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.6-д *"төсвийг зориулалт бусаар зарцуулсан"* гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Өглөг үүсгэдэг, тооцоо нийлж баталгаажуулдаггүй, төлбөр, хураамжийг төсвөөс төлдөг, зориулалт бусаар зарцуулдаг зөрчлийг таслан зогсоож, биелэлтийг 2026 оны 06 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг, даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Болдбаатар, нягтлан бодогч Н.Батаа нарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Х.БАЯРБААТАР

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 Дугаар 228 - А2370456 Чингис хот

ХЭА-2026/099/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баянмөнх сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Сумын Засаг даргын тамгын газрын даргын 2025 оны 11 дүгээр сарын 12-ны өдрийн Б/35 тоот тушаалаар санхүүгийн албаны даргын сул орон тоог нөхөгдөх хүртэл хугацаанд Засаг даргын тамгын газрын нягтлан бодогчид, үндсэн цалингийн 40 хувийн 623,600.00 (зургаан зуун хорин гурван мянга зургаан зуун) төгрөгийн нэмэгдэл цалинг олгосон байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 43 дугаар зүйлийн 43.4-43.5.*"Албан үүргийг түр орлон гүйцэтгэх албан хаагч нь үндсэн албан тушаалаасаа чөлөөлөгдөхгүйгээр албан үүргийнхээ зэрэгцээ түр орлох албан тушаалын чиг үүрэг, эрх хэмжээг хэрэгжүүлж, үр дүнг хариуцна." 43.5."Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд цалин, урамшуулал олгох журмыг төрийн албаны төв байгууллагын саналыг үндэслэн Засгийн газар батална".*

*Төрийн жинхэнэ албан хаагчийн албан үүргийг түр орлон гүйцэтгэхэд, цалин урамшуулал олгох журмын 2.1-д Төрийн албаны тухай хуулийн 42.1-д заасан үндэслэлээр эзгүй байгаа албан хаагчийн албан үүргийг 2-6 сар хүртэл хугацаагаар түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид цалингийн зөрүүг олгоно. 2.2-д Энэ журмын 2.1-д заасан түр орлон гүйцэтгэх хугацаа нь 6 сараас дээш үргэлжлэх бол түр орлон гүйцэтгэж байгаа албан тушаалын цалингийн 40 хүртэл хувийг түр орлон гүйцэтгэсэн төрийн жинхэнэ албан хаагчид олгоно* гэснийг тус тус зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө"*, Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т "хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал." гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Хууль тогтоомжид нийцэхгүй нэмэгдэл цалин олгодог зөрчлийг арилган, биелэлтийг 2026 оны 5 дугаар сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Болдбаатарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Х.БАЯРБААТАР

ХЭНТИЙ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР
АЛБАН ШААРДЛАГА

2026 оны 02 сарын 25 Дугаар 229-А2370456 Чингис хот

ХЭА-2026/099/НА-СТА-ТШЗ

Зөрчил арилгах тухай

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлд заасан Төрийн аудитын байгууллагын бүрэн эрхийн хүрээнд Хэнтий аймгийн Баянмөнх сумын Засаг даргын тамгын газрын 2025 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитаар дараах зөрчил илэрлээ. Үүнд:

Тус байгууллага нь төрийн захиргааны албан хаагчийн сул орон тоо гарсан тухай бүрд олон нийтэд мэдээлэхгүй, Төрийн албаны салбар зөвлөлд сул орон тооны захиалга хүргүүлэлгүй Засаг даргын тамгын газрын дарга, Төрийн сангийн мэргэжилтэн, Санхүүгийн албаны дарга, Хоршоо, хүнс, жижиг дунд үйлдвэр хариуцсан мэргэжилтэн, Нийгмийн бодлогын мэргэжилтэн нарын албан үүргийг шаардлага хангаагүй иргэдээр түр орлон гүйцэтгүүлж байна.

Энэ нь Төрийн албаны тухай хуулийн 27 дугаар зүйлийн 27.2-т “Төрийн жинхэнэ албан тушаалын сул орон тоо гарсан тохиолдолд томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан олон нийтэд мэдээлэх үүрэгтэй. Томилох эрх бүхий байгууллага, албан тушаалтан сул орон тоо гарсан өдрөөс хойш энэ тухай мэдээллийг долоо хоногт, сонгон шалгаруулалт явуулах захиалгыг 21 хоногт багтаан төрийн албаны холбогдох шатны байгууллагад хүргүүлнэ.” гэснийг зөрчсөн байна.

Иймд "Төрийн аудитын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1-д *"Шалгагдагч этгээд хууль тогтоомж, захиргааны хэм хэмжээний болон бусад эрх зүйн акт зөрчсөн, хуулиар хүлээсэн албан үүргээ биелүүлээгүй бол алдаа, зөрчлийг таслан зогсоох, давтан гаргуулахгүй байх талаар байгууллага, албан тушаалтанд албан шаардлага өгнө*", Монгол улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/95 тушаалаар батлагдсан "Албан шаардлага өгөх, төлбөрийн акт тогтоох журам"-ын 4.2.1.11-т “хууль тогтоомж, гэрээ, хэлцэл зөрчсөн алдаа, зөрчлийг таслан зогсоож, давтан гаргуулахгүй байх үр нөлөөтэй гэж үзсэн бусад нөхцөл байдал.” гэж заасныг үндэслэн **ШААРДАХ нь:**

1. Төрийн захиргааны албан хаагчийн сул орон тоог тухай бүрд олон нийтэд мэдээлдэггүй, Төрийн албаны салбар зөвлөлд захиалга өгч нөөцөөс бүрдүүлдэггүй, шаардлага хангаагүй иргэдээр түр орлон гүйцэтгүүлдэг зөрчлийг арилган, биелэлтийг 2026 оны 9 дүгээр сарын 20-ны өдрийн дотор аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэх.

2. Цаашид зөрчлийг давтан гаргахгүй байх, хууль тогтоомжийг хэрэгжүүлж ажиллахыг даргын албан үүргийг түр орлон гүйцэтгэгч Ц.Болдбаатарт даалгав.

**АЛБАН ШААРДЛАГА ӨГСӨН:**

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР Ж.ГАНБААТАР

АУДИТОР Х.БАЯРБААТАР